

**ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР ДАХЬ ХЯТАД,
ОРОС, МОНГОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ГҮНЗГИЙРҮҮЛЖ, ЦАХИМ
ХУДАЛДААНЫ ШИНЭ ОРОН ЗАЙГ ХАМТДАА НЭЭХ НЬ**— Хятад, Орос,
Монголын Худалдаа, аж үйлдвэрийн XIX чуулга уулзалтад тавих илтгэл

Хятадын ӨМӨЗОрны У Хай хотын худалдааг дэмжих хорооны дарга Ян Зи Чин

2026 оны 9 дүгээр сар

Эрхэм хүндэт удирдлагууд аа, хүндэт зочид оо, бизнес эрхлэгч найз нөхөд өө,

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе!

Алтан шаргал намрын есдүгээр сард тэнгэр цэлмэг сайхан байна. Үхай хотын Худалдааг дэмжих хороо төлөөлөн үзэсгэлэнт Улаанбаатар хотноо хүрэлцэн ирж, Хятад, Орос, Монголын Худалдаа, аж үйлдвэрийн XIX чуулга уулзалт болон “Улаанбаатар Түншлэл — Олон улсын хүнсний үйлдвэрлэл, худалдааны үзэсгэлэн”-д оролцож байгаадаа баяртай байна. Энэ удаагийн чуулга уулзалт “Дэлхийн эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн нөхцөл дэх худалдаа, аж үйлдвэрийн танхимуудын хамтын ажиллагаа — сорилт ба боломж” сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж байна. Өнөөгийн дэлхийн худалдаа, эдийн засгийн бүтэц гүнзгий өөрчлөгдөж буй нөхцөлд энэхүү сэдэв нь онцгой ач холбогдолтой бөгөөд цаг үеэ олсон гэж үзэж байна. Юуны өмнө чуулга уулзалтыг зохион байгуулагч МҮХАҮТанхим, мөн Бүх Хятадын Олон улсын худалдааг дэмжих хороо болон ОХУ-ын Худалдаа, аж үйлдвэрийн танхимд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Бизнесийн салбарын хамтын ажиллагааны өндөр түвшний энэхүү талбарыг бүрдүүлсэн та бүхэнд баярлалаа.

Өнөөгийн байдлаар, ӨМӨЗОрон нь Хятадын Чөлөөт худалдааны туршилтын бүс байгуулах зөвшөөрөл авсан боломжийг ашиглан, “Бүс ба Зам” санаачилга болон Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтад улам гүнзгий нэгдэж байна. Илүү нээлттэй, илүү бодитой арга хэмжээгээр Хятадын умард зүгт байх чухал түшиц бүсийг цогцлоохоор идэвхтэй ажиллаж байна. Үхай хот нь Өвөрмонголын баруун хэсгийн шинээр хөгжиж буй аж үйлдвэрийн хотын хувьд Өөртөө Засах Орны нээлттэй хөгжлийн ерөнхий бодлогод идэвхтэй нэгдэж, гурван улсын хамтын ажиллагаанд өөрийн хувь нэмрийг оруулж байна.

1. Хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд Өвөрмонгол худалдаа, эдийн засгийн хүчирхэг хөдөлгөгч хүчтэй

Энэ оны эхний хагас жилийн байдлаар Өвөрмонголын бараа бүтээгдэхүүний гадаад худалдааны нийт хэмжээ 131.46 тэрбум юаньд хүрч, өмнөх оны мөн үеэс 29.3 хувиар өссөн бөгөөд өсөлтийн хурдаар Хятад улсын хэмжээнд 6 дугаар байрт орсон.

Үүнээс Монгол Улстай хийсэн импорт, экспортын хэмжээ 55.21 тэрбум юаньд хүрч, 59 хувиар, ОХУ-тай хийсэн импорт, экспортын хэмжээ 21.2 тэрбум юаньд хүрч, 64.7 хувиар тус тус өссөн байна.

Эдгээр тоон үзүүлэлт нь Хятад, Орос, Монгол гурван улсын зах зээл харилцан бие биеэ нөхөх давуу талтай бөгөөд хамтын ажиллагааны асар өргөн боломж байгааг бүрэн харуулж байна. Өвөрмонгол нь Хятад, Орос, Монголын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тэргүүн эгнээнд оршдог бүс нутгийн хувьд хөгжлийн хүчирхэг эрч хүч, хамтын ажиллагааны асар их нөөц боломжоо харуулж байна.

Энэ үйл явцад Үхай хот ч мөн тодорхой хэмжээний нөлөө үзүүлсэн юм. Энэ оны эхний хагас жилд Үхай хотын импорт, экспортын нийт хэмжээ 2.011 тэрбум юаньд хүрч, өмнөх оны мөн үеэс 132.29 хувиар өссөн бөгөөд өсөлтийн хурдаар Өвөрмонголд тэргүүлсэн байна.

Бид Монгол Улсын нүүрсний цахим дуудлага худалдаа тогтмолжиж буй боломжийг идэвхтэй ашиглан, ойролцоох боомтуудын тээвэр, логистикийн давуу талыг бүрэн ашиглаж байна. Үүний үр дүнд нүүрс зэрэг их хэмжээний нөөцийн бүтээгдэхүүний импорт тасралтгүй нэмэгдэж, орон нутгийн нарийн химийн үйлдвэрлэл болон нүүрс-химийн үйлдвэрлэлийн тогтвортой үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн өсөлтийг хангах бат бөх суурь бүрдэж байна.

2. Хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд Өвөрмонголын аж үйлдвэрийн хэтийн төлөв арвин их.

Өвөрмонгол “дамжин өнгөрөх эдийн засаг”-аас “орон нутагт суурилсан эдийн засаг” руу шилжих үйл явцыг эрчимтэй дэмжиж байна. Эрчим хүч, нөөц баялгийн хамтын ажиллагааны хувьд Өвөрмонголын түүхий эдийн импорт тогтвортой нэмэгдэж байна. Энэ оны эхний хагас жилд зэс, хар тугалга, цайр зэрэг металлын хүдрийн импорт 49.11 тэрбум юаньд хүрч, 44.1 хувиар өссөн бол нүүрс, түүхий нефть зэрэг эрчим хүчний бүтээгдэхүүний импорт 20.2 тэрбум юаньд хүрч, 31.5 хувиар өссөн байна.

Монгол Улс ашигт малтмалын арвин нөөцтэй, харин Өвөрмонгол эрчим хүч, химийн үйлдвэрлэлийн иж бүрэн тогтолцоотой. Иймээс хоёр талын эрчим хүч, нөөц баялгийн салбар дахь хамтын ажиллагааны орон зай асар өргөн юм.

Шинээр хөгжиж буй салбаруудын хамтын ажиллагааны хувьд Өвөрмонгол шинэ эрчим хүч, шинэ материал, ногоон тооцоолох хүчин чадал зэрэг стратегийн шинэ салбаруудыг хөгжүүлэхэд анхаарч байна.

Үхай хот ч энэхүү боломжийг идэвхтэй ашиглаж байна. Өвөрмонголын нүүрс-хими болон нарийн химийн үйлдвэрлэлийн чухал баазын хувьд Үхай хот харьцангуй бүрэн хөгжсөн тойрог эдийн засгийн үйлдвэрлэлийн сүлжээ бүрдүүлсэн бөгөөд нүүрс зэрэг нөөцийн бүтээгдэхүүнийг тогтвортой, тасралтгүй импортлох эрэлт хэрэгцээтэй.

Үүний зэрэгцээ Үхай хот шинэ эрчим хүчний батареин материал ба тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, мөн биологийн задралд ордог шинэ материал гэсэн хоёр томоохон аж үйлдвэрийн кластерийг хөгжүүлэхэд хүчээ төвлөрүүлж байна. Ингэснээр Үхай хотын шинэ салбаруудын өрсөлдөх чадвар тасралтгүй нэмэгдэж байна.

3. Хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд цахим худалдаа Өвөрмонголын шинэ хөдөлгөгч хүч болж байна

Дижитал эдийн засгийн эрин үед цахим худалдаа Хятад, Орос, Монголын худалдаа, хөрөнгө оруулалтын бүтцийг гүнзгий өөрчилж байна.

Нэгдүгээрт, онлайн худалдаа газар зүйн хил хязгаарыг давж, гурван улсын жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд хил дамнасан цахим худалдааны талбараар дамжуулан эрэлт, нийлүүлэлтээ шууд холбох боломж олгож байна. Ингэснээр арилжааны зардал буурч, худалдааны үр ашиг нэмэгдэнэ.

Хоёрдугаарт, дижитал төлбөр тооцоо болон хил дамнасан логистикийн хурдацтай хөгжил нь их хэмжээний түүхий эдээс гадна өргөн хэрэглээний бараа, хөдөө аж ахуй, мал аж ахуйн бүтээгдэхүүн, үйлдвэрийн сэлбэг хэрэгсэл зэрэг бүтээгдэхүүнийг өндөр давтамжтай, бага хэмжээгээр, захиалгат хэлбэрээр худалдаалах боломжийг бүрдүүлж, уламжлалт их хэмжээний худалдааны загварыг нөхөж байна.

Гуравдугаарт, цахим худалдаа нь шууд дамжуулалтаар бүтээгдэхүүн борлуулах, дижитал үзэсгэлэн, хил дамнасан нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт зэрэг бизнесийн шинэ хэлбэрүүдийг бий болгож, гурван улсын онцлог бүтээгдэхүүнийг шинэ зах зээлд гаргах сувгийг нээж байна.

Цаашид Үхай хот Монгол, Оросын аж ахуйн нэгжүүдтэй хамтран дижитал худалдааны экосистем бүрдүүлж, мэдээлэл солилцоо болон хүний нөөцийн харилцааг дэмжин, цахим худалдааг Хятад, Орос, Монголын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны “шинэ хөдөлгүүр” болгоход бэлэн байна.

Хүндэт зочид оо!

Хятад, Орос, Монгол гурван улс бол харилцан чухал хөршүүд бөгөөд гурван улсын бизнесийн салбарын хамтын ажиллагааны нөөц боломж асар их, ирээдүйтэй байна. Энэ удаагийн чуулга уулзалтын сэдэвт дурдсанчлан, дэлхийн эдийн засгийн бүтэц гүнзгий өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд худалдаа, аж үйлдвэрийн танхимуудын хамтын ажиллагаанд сорилт тулгарч байгаа хэдий ч үүний зэрэгцээ асар их боломж нээгдэж байна. Бид Монгол Улс болон ОХУ-ын бизнесийн салбарын анд нөхөдтэй гар нийлэн ажиллаж, худалдаа, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа зэрэг салбарт илүү шинэ үр дүнд хүрч, Хятад, Орос, Монголын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны шинэ хуудсыг хамтдаа бичихийг чин сэтгэлээсээ хүсэж байна!

Эцэст нь, энэхүү чуулга уулзалт болон үзэсгэлэн худалдаа амжилттай зохион байгуулагдахыг хүсэн ерөөе!

Та бүхэнд эрүүл энх, ажил үйлс нь өөдрөг, амжилт бүтээлээр дүүрэн байхыг хүсье!

Баярлалаа!